

ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2022 оны 03 сарын 16

№ ТУЗ 22/2

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
зарлан хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61.1.5, 67.1, 71.3, 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14 ны өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн зар хүргэх журам”, Глобал лайф технологи ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2022 оны 3-р сарын 16-ний өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4 сарын 27- ны өдрийн Лхагва гарагийн 14:00 цагт “Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Санто апартамент оффис тоот” хаягт зарлан хуралдуулсугай.
2. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 сарын 7-ны өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг “хавсралт №1”-ээр баталсугай.
4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2022 оны 3 сарын 21-ний өдөр болон, давтан 15 хоногийн дараа буюу 04 сарын 05- ны өдрөөр тогтоож, зарын агуулгыг “хавсралт №3”-аар баталсугай.
5. Хувьцаа эзэмшигчдэд ээлжит хурлын материалыг 2022 оны 3 сарын 25-ний өдөр үнэт цаасны компанид цахим шуудан болон бичгээр илгээх ба хувьцаа эзэмшигчид компанийн байранд 3 сарын 21 ний өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд ирж танилцаж болохыг түгээсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг “хавсралт №2”-аар баталсугай.
7. Бичгээр санал авах хуудсыг хүлээж авах сүүлийн хугацааг 2022 оны 4 сарын 26-ны өдрийн 17 цагаас өмнө компанийн байранд ирүүлсэн байхаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал авах хуудсыг “хавсралт №4”-өөр баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар гүйцэтгэх захирал He Jingwen, гишүүнээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т. Баярмаа нарыг томилсугай.
10. Хурлын тооллогын комиссын даргаар Г. Ариунчимэг, гишүүнээр З. Төгөлдөр нарыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



YEN MONTGOMER
/YEN MONTGOMER/